# ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

ОРХОН АЙМАГТ 2023 ОНЫ БАЙДЛААР 0-18 НАСНЫ 39,295 ХҮҮХЭД АМЬДАРЧ БАЙНА.







## ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН 108 ДУГААРТ ИРСЭН ДУУДЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ




Хүүхэд хамгааллын зардалд 2021-2023 онд 353.7 сая төгрөг зарцуулжээ

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

1.Аймгийн бодлогын баримт бичгүүдэд хүүхэд хамгааллын үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхой, үр дүнг хэмжиж болохуйц байдлаар тусгах шаардлагатай.

2.Хүүхэд хамгааллын чиглэлийн мэргэшсэн албан хаагч тогтвортой ажиллуулах, мэдээллийн сан бүрдүүлэхэд анхаарах.

3.Хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийдэггүйгээс төсвийг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

4.Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтын ил тод байдлыг бүрэн хангаагүй, зарим зардлыг хэмнэлтгүй зарцуулсан байна.

5.Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар судалгаа шинжилгээ хийж, нийгэмд гарах нөлөөллийг тооцох.

6.Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд гэр бүлийн орчинд анхаарах.

7.Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үр нөлөө багатайгаас шалтгаалан хүүхэд хамгааллын зөрчил буурахгүй байна.

## ЗӨВЛӨМЖ

### Аймгийн Засаг дарга бөгөөд хүүхдийн төлөө зөвлөлийн даргад

*2020 онд барьж эхэлсэн хүүхдийн хөгжил хамгааллын төвийн барилгыг ашиглалтад оруулахад онцгой анхаарах
*Аймгийн бодлогын баримт бичгүүдэд хүүхэд хамгааллын үйл ажиллагааны зорилго, зорилтыг тусгах, салбар хоорондын уялдааг сайжруулах

### Сумдын Засаг дарга нарт

Хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй багийн албан хаагчдын хоорондын уялдаа холбоог сайжруулж, мэргэжлийн бус албан хаагч ажиллуулахгүй байх

### Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт

*Хамтарсан баг, ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдийн хувь хүний нууц хамгаалах хууль, журмын мөрдөх, хөтлөх сургалт зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх
*Эрх бүхий байгууллагаас баталсан журам, аргачлалын дагуу үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичиг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүн, үр нөлөөг үнэлж байх.
*Хүүхдийн эрх, хамгааллын статистик бүртгэлийн үнэн зөв байдалд хяналт хэрэгжүүлж, дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаа төлөвлөх.